



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

“Даатгалын мэргэжлийн оролцогчийн
үйл ажиллагаанд тавигдах шаардлага” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ыг хавсралтаар баталсугай.

2. Шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ шаардлагын зорилго нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.1-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

~~1.2. Даатгалын мэргэжлийн оролцогч хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан нь Хорооны 2007 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх төхирөмжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан шаардлагыг хангасан байна.~~

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

Хоёр. Нэр томьёо

2.1. Энэхүү шаардлагад хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

~~2.1.1. “даатгалын зуучлалын үйл ажиллагаа” гэж даатгалын эредэлийн талаар зөвлөлгөө өгөх, даатгалын болон давхар даатгалын гэрээ байгуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, даатгалын гэрээг зуучлан борлуулах үйл ажиллагааг.~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

~~2.1.2. “даатгалын хохирол үнэлгээний үйл ажиллагаа” гэж даатгагчаас толох нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохын тулд даатгалын гэрээтэй холбоотой хүсэлт, нэхэмжлэлийн дагуу учирсан хохирол болон холбогдох баримт материалыг хянан шалгаж, хохирлыг тогтоох үйл ажиллагааг~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

~~2.1.3. “Даатгалын толоологчийн үйл ажиллагаа” гэж даатгагчаас олгосон бүрэн эрхийн хүрээнд даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн~~

өмнөөс даатгалын гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, даатгалын нөхөн төлбөртэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааг тус тус ойлгоно.

~~/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10 ны өдрийн 277 дугаар тогтоолоор нэмсэн/~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

Гурав. Даатгалын зуучлагчид тавигдах шаардлага

3.1. Даатгалын зуучлагч нь үйл ажиллагаандаа дараах шаардлагыг байнга хангаж ажиллана:

~~3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн явуулах байнгын ажлын байртай байх, уг байрны хаяг өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор Хороонд бичгээр мэдэгдэх;~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.1.2. Хоёроос доошгүй орон тооны ажилтантай байх;

3.1.3. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах техник тоног төхөөрөмжтэй байх;

3.1.4. Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөх болон санхүүгийн тайлан тодруулга гаргах нягтлан бодогчтой байх ба нягтлан бодогч өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэх;

3.1.5. Компаниас гаргасан шийдвэр болон компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх дотоод дүрэм, журам, заавар, эрх зүйн баримт бичгийг архивлан хадгалах;

3.1.6. Компанийн жилийн болон улирал тутмын санхүүгийн тайланг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан хугацаанд Хороонд ирүүлэх;

3.1.7. Жил бүр мэргэжлийн хариуцлагаа даатгуулсан байх ба мэргэжлийн хариуцлагын даатгалын үнэлгээний доод хязгаар нь 50.0 сая төгрөг байна;

3.1.8. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу даатгалын зуучлалын орлогыг дамжуулан шилжүүлэх тохиолдолд зуучилсан даатгалын хураамжийн орлогыг компанийн бусад орлогоос тусдаа дансанд төвлөрүүлэх бөгөөд уг орлогыг холбогдох гэрээнд заасан хугацааны дотор даатгагчид шилжүүлэх;

3.1.9. Зуучилсан даатгалын гэрээний дэлгэрэнгүй бүртгэлийг тухай бүр хөтлөх;

3.1.10. Даатгалын зуучлалын гэрээ болон хамтран ажиллах гэрээг монгол хэл дээр үйлдэх, эсхүл монгол хэл дээр хөрвүүлсэн байх, мөн тэдгээрийг архивлан хадгалсан байх;

3.1.11. Зуучилсан даатгалын гэрээнд даатгалын зуучлагч гарын үсэг зурж, тэмдэг дарсан байх;

3.1.12. Даатгалын зуучлагч нь даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийн асуудлаар зөвлөгөө туслалцаа үзүүлж болох бөгөөд энэхүү туслалцаа үзүүлсний хөлсийг даатгуулагчаас олгох даатгалын нөхөн төлбөрөөс суутган авахыг хориглоно.

Дөрөв. Даатгалын хохирол үнэлэгчид тавигдах шаардлага

4.1. Даатгалын хохирол үнэлэгч хуулийн этгээд нь Хорооноос баталсан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн харилцааг зохицуулсан журамд заасан шаардлагыг хангахаас гадна үйл ажиллагаандаа дараахь шаардлагыг хангаж ажиллана:

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/

4.1.1. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа явуулах компани нь хариуцлагаа жил бүр даатгуулсан байх ба мэргэжлийн хариуцлагын даатгалын үнэлгээний доод хязгаар нь 50.0 сая төгрөг байна;

~~4.1.2. Үйл ажиллагаагаа хэвийн явуулах байнгын ажлын байртай байх, энэхүү ажлын байр оорчлогдсон тохиолдолд ажлын 5 хоногийн дотор Хороонд бичгээр мэдэгдэж; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

4.1.3. Хоёроос доошгүй орон тооны ажилтантай байх;

4.1.4. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах техник тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;

4.1.5. Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөх болон санхүүгийн тайлан тодруулга гаргах нягтлан бодогчтой байх ба нягтлан бодогч өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэх;

4.1.6. Компанийн жилийн болон улирал тутмын санхүүгийн тайланг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан хугацаанд Хороонд ирүүлэх;

4.1.7. Компаниас гарсан шийдвэр болон компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх дотоод дүрэм, журам, заавар, эрх зүйн баримт бичгийг архивлан хадгалах.

4.2. Даатгалын хохирлын үнэлгээ хийх бэлтгэл ажил нь дараахь шаардлагад нийцсэн байна:

4.2.1. хохирлын үнэлгээний стандарт, аргачлал, дүрэм, журам, норм, норматив болон шаардлагатай бусад материалыг бэлтгэсэн байх;

4.2.2. даатгалын хохирлын үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичгийг үйлчлүүлэгчээс гаргуулан авсан байх;

4.2.3. даатгалын хохирлын үнэлгээ хийхэд ашиглаж байгаа мэдээллийн сан болон үйлчлүүлэгчээс ирүүлсэн тоо, мэдээг дахин хянаж, магадлан шинжилсэн байх.

4.3. Даатгалын хохирлын үнэлгээний тайлан нь хохирлын үнэлгээг тогтоосон үндэслэл, нотолгоог агуулсан үндсэн баримт бичиг байх бөгөөд уг тайлан нь дараахь шаардлагад нийцсэн байна:

4.3.1. тогтоосон даатгалын хохирлын үнэлгээ нь тодорхой үндэслэл бүхий тайлбартай байх;

4.3.2. уг тайланд даатгалын хохирлын үнэлгээ хийх явцад гарсан хохирлын үнэлгээний стандарт, дүрэм, журам, нормыг зөрчсөн аливаа үйлдлийн талаар тэмдэглэсэн байх.

4.4. Даатгалын хохирлын үнэлгээний тайланд дараахь зүйлийг тусгана:

4.4.1. үнэлгээчний нэр, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийн дугаар, Хорооноос баталсан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн харилцааг зохицуулсан журамд заасны дагуу мэргэжлийн хариуцлагаа даатгуулсан талаархи мэдээлэл;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/

4.4.2. учирсан хохирлоо үнэлүүлэх этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар;

4.4.3. даатгалын хохирлын үнэлгээ хийсэн хугацаа болон тайлангийн он, сар, өдөр;

4.4.4. даатгалын хохирлын үнэлгээний зүйлийн төрөл, түүний тухайн үеийн шинж байдлын тодорхойлолт;

4.4.6. даатгалын хохирлын үнэлгээний зүйлийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын талаархи мэдээлэл;

4.4.7. даатгалын хохирлын үнэлгээний зүйлийн хамрах хүрээ, хязгаар;

4.4.8. даатгалын хохирлын үнэлгээ хийхэд ашигласан 3-аас доошгүй газрын үнийн судалгаа, түүнд хийсэн тооцоолол;

4.4.9. даатгалын хохирлын үнэлгээний дүн.

4.5. Даатгалын хохирлын үнэлгээний тайланд үнэлгээчин гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

4.6. Даатгалын хохирол үнэлэгч дараахь тохиолдолд даатгалын хохирлын үнэлгээ хийхийг хориглоно:

4.6.1. Даатгалын хохирол үнэлэгч нь өөрсдийн ажиллаж буй үнэлгээний компанийн ажилтан бол өөрт учирсан даатгалын хохиролд үнэлгээ хийх;

4.6.2. үнэлгээчин өөрийн ажилладаг компанийн даатгалын хохиролд үнэлгээ хийх;

4.6.3. төрөл, садан /эцэг, эх, нөхөр, эхнэр, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү гэх мэт/-ын даатгалын хохиролд үнэлгээ хийх;

4.6.4. тухайн үнэлгээний компанийн санхүүгийн тайланд аудит хийсэн хуулийн этгээдийн учирсан хохиролд үнэлгээ хийх.

4.7. Энэ журмын 4.5-д заасан даатгалын хохирлын үнэлгээний тайланд хохирлоо үнэлүүлсэн этгээд танилцаж зөвшөөрсөн гарын үсэг зурсан байна.

Тав. Даатгалын төлөөлөгчид тавигдах шаардлага

5.1. Даатгалын төлөөлөгч нь Хорооноос баталсан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн харилцааг зохицуулсан журамд заасан шаардлагыг хангахаас гадна дараах шаардлагыг хангаж ажиллана:

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/

5.1.1. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааны орлого нь 20.0 сая төгрөг ба түүнээс дээш хэмжээтэй бол даатгалын төлөөлөгч өөрийн орлогын тайлангаа Хорооноос баталсан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журмын холбогдох хавсралтын дагуу төлөөлж буй компанидаа мөн журамд заасан хугацаанд гаргаж өгөх.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/

5.1.2. Даатгалын төлөөлөгч нь энэ журамд заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхэлснийхээ төлөө даатгагчаас төлбөр, хөлс авах эрхтэй бөгөөд уг үйл ажиллагааг явуулаагүй тохиолдолд даатгагчаас аливаа төлбөр, хөлс авахыг хориглоно.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 277 дугаар тогтоолоор нэмсэн/

5.1.3. Даатгуулагч нь хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулсныхаа төлөө даатгагчаас хүлээн авч буй төлбөр, хөлсний талаар даатгалын төлөөлөгч нь даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө даатгуулагчийн эрх бүхий албан тушаалтанд бичгээр мэдэгдэж, танилцуулсан байна. Энэхүү төлбөр, хөлсийг даатгалын төлөөлөгчид олгохыг зөвшөөрсөн даатгуулагчийн гарын үсэг бүхий мэдэгдлийг даатгагчийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.

/ Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 277 дугаар тогтоолоор нэмсэн/

/ Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 372 дугаар тогтоолоор өөрчилсөн/

Зургаа. Даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн хөрөнгийн байршилд тавигдах шаардлага

6.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн Хорооноос тогтоосон дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн доод хэмжээний 50 хүртэл хувийг тухайн компанийн өөрийн үйл ажиллагаанд зориулагдах хөрөнгө хэлбэрээр байршуулж болно.

6.2. Даатгалын мэргэжлийн оролцогчийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд Компанийн тухай хуулийн 31.3-т “Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу шийдвэрлэнэ.

6.3. Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдлийн хэмжээ нийт активын 10 хувиас хэтрэхгүй байна.

Долоо. Даатгалын мэргэжлийн оролцогчийн салбарт тавигдах шаардлага

7.1. Хорооноос баталсан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн харилцааг зохицуулсан журамд заасан шаардлагыг хангаж ажиллана.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/

~~7.2. Даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч хуулийн этгээдийн салбарын хаяг өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэнэ.~~

~~*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*~~

Найм. Хяналт, хариуцлага

8.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтэд Хорооны Ажлын албанаас хяналт тавьж ажиллана.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/

8.2. Энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээдэд даатгалын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.